



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/241


Мөрөн сум

Стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
2. Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг Төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусгах, байгууллагын болон Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд)-д үүрэг болгосугай.
3. Орон нутгийн өмчийн газрын стратеги төлөвлөгөө батлах тухай 2017 оны А/63 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.
4. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

Аймгийн засаг даргын 2019 оны
6 дугаар сарын 7-ны өдрийн
А/241 дүгээр захирамжийн хавсралт

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2019-2024 ОН)**

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Стратеги төлөвлөгөө боловсруулах эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Засгийн газрын “Засаг даргын тамгын газрын орон бүтэц тогтоох тухай” 2016 оны 09 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн “Орон нутгийн өмчийн газрын бүтэц, орон тоо тогтоох тухай” 2016 оны 65 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Орон нутгийн өмчийн газар байгуулах тухай” 2016 оны А/441 дүгээр захирамжийг тус тус үндэслэн аймгийн орон нутгийн өмчийн газрыг 2016 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан болно. Монгол Улсын төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү стратеги төлөвлөгөөг боловсруулав.

1.2. Хууль тогтоомжийн орчин:

- Монгол улсын үндсэн хууль
- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Иргэний хууль
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Барилгын тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Авилгын эсрэг хууль
- Компанийн тухай хууль
- Бусад хууль, тогтоомжууд

1.3 Газрын үйл ажиллагааны стратеги зорилтууд: Газар нь өөрийн чиг үүрэг, эрхэм зорилгоо хангахын тулд стратегийн дараах зорилтыг дэвшүүлж байна. Орон нутгийн өмчийн харилцааны болон худалдан авах ажиллагааны талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх хэтийн болон богино хугацааны төлөвлөлттэй уялдуулан төлөвлөж, хэрэгжилтийг хангаж, үр дүнг аймгийн ИТХ, Засаг даргад тайлагнах үүрэг хүлээнэ.

1.4. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр:


Аймгийн Орон нутгийн өмчийн газрын стратегийн удирдлага зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр нь дор дурьдсан удирдлага, үйлчлүүлэгч, хэрэглэгчийг хамаарна.

Орон нутгийн өмчийн газрын үйлчлүүлэгч нь аймгийн ИТХ, түүний тэргүүлэгч, аймаг, сумдын ЗДТГ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд, төрийн ба төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, иргэд олон нийт байна.

Стратегийн удирдлага зохицуулалт нь дээр дурьдсан үйлчлүүлэгч хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдсон харилцааг хууль, эрх зүйн хүрээнд зохицуулахад чиглэгдэнэ.

Орон нутгийн өмчийн газрын стратегийн удирдлага зохицуулалтын хэрэгцээг хангах, үйлчилгээний хүрээ, төрөл хэлбэрт тохирсон газрын зохион байгуулалтын бүтцийн зорилт, чиг үүргийг үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөтэй уялдуулан нарийвчлан тогтоож хэрэгжүүлнэ.

1.5 Стратеги төлөвлөгөөний ач холбогдол: Стратеги төлөвлөгөө нь газрын эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд нөөц бололцоо, хүчин чармайлт, цаг хугацаагаа юунд төвлөрүүлэх вэ гэдгийг тодорхойлж хамтдаа хөгжих бодлогын баримт бичиг юм. Дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд бидний өмнө ямар асуудал тулгарч байгааг тодорхойлж, түүнийг даван туулах аргачлал, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж үр дүнд хүрэх бодлогын чиглэл болно. Стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлснээр иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгож, өмчийн болон худалдан авах ажиллагааны салбарын бодлогын уялдаа холбоо хангагдан, байгууллагын дотоод зохион байгуулалт боловсронгуй болно.



Газрын хөгжлийн үзэл баримтлал, эрхэм зорилго, үйл ажиллагааны хэтийн төлөв, хүрэх үр дүнгийн төсөөллийг стратеги төлөвлөгөөнд тусгасан бөгөөд газрын дүрэм, нэгжийн дүрэм зэрэгтэй нягт уялдуулж боловсрууллаа.

ХОЁР. ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1 Газрын 2017-2019 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт


Хөвсгөл аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг аймгийн орон нутгийн өмчийн газар нь Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 09 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2016 оны 9 дүгээр сарын 21-ны өдрийн А/441 дугаар захирамжийн дагуу бүтэц, орон тоогоо шинэчлэн 2 хэлтэс, 1 хэсэгтэй, 12 хүний орон тоотойгоор ажилласан. Үүнд:

- Захиргаа, санхүүгийн хэсэг,
- Худалдан авах ажиллагааны хэлтэс
- Өмчийн харилцааны хэлтэс

Газрын 2017-2019 оны стратеги төлөвлөгөөний онцлог нь нэгжүүдийн чиг үүргийг тодотгож үндсэн 11 стратегийн зорилтыг тодорхойлж зорилт, үр дүнгийн шинжилгээг хийж төлөвлөсөн үр дүнгээ тодорхойлсон байна. Уг стратеги төлөвлөгөөнд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотойгоор ажил, үйлчилгээ, арга хэмжээг ямар хугацаанд хэрхэн дүгнэх, шинэчлэх, сайжруулах асуудлыг нарийвчлан тусгаагүй байна. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, хөрөнгө оруулалтын ажлын чанар дээшилсэн бөгөөд худалдан авах ажиллагааг 100 хувь цахимжуулж, худалдан авах ажиллагаанд ил тод, нээлттэй, өрсөлдөх боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчимуудыг хэрэгжүүлж, орон нутгийн өмчийн удирдлагад эрс шинэчлэл хийж, орон нутгийн өмчит болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудыг орон нутгийн өмчит хувьцаат компани болгон өөрчлөн байгуулж, 1,1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан аж ахуйн нэгжүүд 2018 онд 1,6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, Улсад болон салбартаа ажлын амжилтаараа тэргүүлсэн агентлаг боллоо. Стратеги төлөвлөгөөнд туссан зорилт тус бүрийг төрийн бодлого, хууль тогтоомжийн заалттай уялдуулж жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг хангуулан ажилласан болно.

№	Бодлогын зорилт	Арга хэмжээний тоо	Биелэлт
1	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	5	87,8
2	Улсын Их хурлын болон Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл	8	79,5
3	Аймгийн ИТХ, тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэрийн биелэлт биелэлт	25	89,8
4	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	13	75,6
5	2018 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	14	89,1
6	Засаг даргын Засгийн газрын гишүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилт	5	100
7	Аймгийн Засаг даргын захирамжийн биелэлт	279	98,2
Нийт			88,6

ГАЗРЫН 2017-2019 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ График 1



2.2 Гадаад орчны шинжилгээ

Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулахад гадаад орчны хүчин зүйлсийн нөлөөлөл, шалтгааныг шинжлэх шаардлагатай байдаг. Тодруулбал, газрын үйл ажиллагаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, аймгийн ИТХ, Засаг даргын дэмжлэг ямар хүчин зүйлүүд дээр хэрэгтэй, эдгээр хүчин зүйлсийн хувьд тус газрын үйл ажиллагаанд ямар давуу талуудтай байгаа зэргийг тодорхойлон гаргахад чиглэдэг.

Гадаад орчны шинжилгээ (дэмжлэг)	
Орчны хүчин зүйлс	Тайлбар
Улс төрийн хүчин зүйлс	“Хөгжсөн Хөвсгөл 2016-2030” аймгийн хөтөлбөрийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан хүртэлх
	Орон нутгийн өмчийн харилцааны журмыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар баталсан
	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2019 онд нэмэлт өөрчлөлт оруулсан
Эдийн засгийн хүчин зүйлс	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ жил ирэх тусам өсч, төрийн худалдан авалтын хэмжээ, тендерт оролцогчийн оролцогчийн тоо нэмэгдэж байна.
	Орон нутгийн өмчийн барилга байгууламжууд шинээр баригдаж, засварлагдаж, нийгэм, соёлын салбарын барилга байгууламж шинэчлэгдсэн байна.
Нийгмийн хүчин зүйлс	Төрийн худалдан авалтын талаар иргэд, олон нийтийн ойлголт эерэг хандлагатай болсон,
	Төрийн өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтанд тавих

	иргэд, олон нийтийн хяналт сайжирч, нийтийн өмч хөрөнгийг хамгаалах санаачлага нэмэгдсэн
Технологийн хүчин зүйлс	Иргэд олон нийтийн мэдээллийн технологийн дэвшил, цахим орчинд ажиллах мэдлэг, чадвар дээшилсэн
	Орон нутгийн өмчийн удирдлагын нэгдсэн мэдээллийн системийн хөгжүүлэлт, дүүргэлт сайжирсан

2.3 Дотоод орчны шинжилгээ

Аливаа стратегийн шинжтэй шийдвэр гаргах, төлөвлөгөө боловсруулахын тулд байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлдөг дотоод, гадаад орчныг судлах шаардлагатай болдог бөгөөд байгууллагын алсын хараа, урт хугацааны зорилтууд, стратегийн төсөл хөтөлбөрүүдийг тодорхойлоход СВОТ шинжилгээг ашигладаг.

Газрын дотоод орчны шинжилгээг хийхдээ нийт албан хаагчид, нэгжүүдээс авсан судалгааны дүнг нэгтгэж Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж гарсан санал, зөвлөмжийг тусгасан.

Байгууллагын дотоод орчны шинжилгээ	
Давуу тал	Сул тал
Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр туршлага хуримтлуулж Улс, аймагтаа арга туршлагаа дэлгэрүүлсэн	Газрын хүний нөөцийн мэргэшсэн байдал хангалтгүй
Мэргэжлийн боловсон хүчний залгамж чанартай	Аймаг орон нутгийн удирдлагын зүгээс боловсон хүчнийг дэмжих, хөгжүүлэх талаар төдийлөн анхаарал тавихгүй байна.
Байгууллагын дотоод уур амьсгал, эв нэгдлийг бэхжүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг	Гадаадад мэргэжлийн чиглэлээр туршлага судлах сургалт, семинарт тэгш хамруулах талаар анхаардаггүй
Нийт албан хаагчдын 72,7 хувь нь 5-аас 30 жил төрд ажилласан туршлагатай	Шинэ санаа, бүтээлч үйл ажиллагааг идэвхжүүлэх талаар анхаарахгүй байгаа
Компанийн засаглалыг хөгжүүлэх чиглэлээр туршлага хуримтлуулсан	Нэгжүүдийн хоорондын уялдаа холбоо, мэдээлэл солилцох байдлыг сайжруулах шаардлагатай
Байгууллагын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд байгууллагын удирдлагын зүгээс анхаардаг	Төрийн албан хаагчдын идэвх санаачлага хангалтгүй, харьцаа хандлага, ёс зүйн хариуцлагаа өөрчлөх шаардлагатай
Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт "хангалттай сайн"	Байгууллагын төлөвлөлтийг хэрэгжүүлэх гүйцэтгэлийн удирдлага хангалтгүй
Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг тэгш, хүнд суртал, чирэгдэлгүй, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хүргэж хэвшсэн	Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих үйл ажиллагаанд тухайн салбарын чиг үүргийн байгууллагуудын идэвх санаачлага, хамтын ажиллагаа хангалтгүй
Боломж	Аюул
Хүний нөцийн тогтвортой бодлого хэрэгжүүлэх	Бусад агенлаг, байгууллагатай чиг үүргийн давхардал гарах
Боловсон хүчнийг мэргэшүүлэх	Зохион байгуулалтын бүтцийг төлөвшөөгүй байхад бүтэц, зохион байгуулалт өөрчлөх
Мэргэжлийн чиглэлээр албан хаагчдыг гадаад, дотоодын туршлага судлах боломжоор хангах	Үйл ажиллагаа (орон бүтцэд)-нд шаардлагатай байгаа төсөвийг хэрэгцээт хэмжээгээр хуваарилахгүй, батлахгүй байх
Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах	
Хувь хүний хөгжлийг дэмжих	
Нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулах зорилгоор тогтмол мэдээллийн цагтай болох	

Газрын үйл ажиллагаанд мэдээллийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр хангах	
Үйл ажиллагаанд шаардлагатай дүрэм журмуудыг шинээр боловсруулах, шинэчлэх	

ГУРАВ. ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1 Газрын үзэл баримтлал, алсын хараа, эрхэм зорилго

Хөгжлийн үзэл баримтлал: Хууль тогтоомжийг чандлан мөрдөж, төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэн, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтална.

Алсын хараа: Үйлчлүүлэгч, түншлэгчдийн итгэлийг хүлээж, үйл ажиллагааны үр дүнгээрээ улс, аймагт манлайлагч төрийн байгууллагын нэгэн болох явдал мөн.

Эрхэм зорилго: Орон нутгийн өмчийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг дээшлүүлэхэд өмчийн удирдлагын олон улсын жишигт нийцсэн шилдэг загварыг нэвтрүүлнэ.

3.2 Бидний эрхэмлэх үнэт зүйлс:

3.2.1 **Мэдлэгийг эрхэмлэх:** Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай мэдлэгтэй байж, түүнийгээ цаг үеийн эрэлт шаардлагад нийцүүлэн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлнэ.

3.2.2 **Чадварыг эрхэмлэх:** Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд зохистой арга барил, ур чадвар, орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг эзэмшиж, түүнийгээ ажлаа чадамгай, үр бүтээлтэй гүйцэтгэхэд ашиглана.

3.2.3 **Хууль ёсыг эрхэмлэх:** Төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах болон төрийн албаны бүхий л үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн сахина.

3.2.4 **Ёс зүйг эрхэмлэх:** Төрийн албаны ёс зүйн үнэт зүйлс, зарчим, хэм хэмжээг сахин ажиллана.

3.2.5 **Шударга ёсыг эрхэмлэх:** Газрын үйл ажиллагаа явуулах, үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гаргахад аливаа хэлбэрээр ялгаварлахгүй, ямарваа хөндлөнгийн нөлөөлөлд орохгүй, ашиг сонирхлын аливаа зөрчилд автахгүйгээр зөвхөн нийтийн ашиг сонирхолд нийцүүлж, чин шударгаар ажиллана.

3.2.6 **Соёлтой харилцааг эрхэмлэх:** Иргэдэд байнга хүндэтгэлтэй хандаж, тэдний итгэлийг олох хэмжээнд харилцааны соёлыг эзэмшин, үйл ажиллагаа, үйлчилгээгээ эелдэг, ил тод байлгаж, олон нийтийн санаа бодлыг байнга авч, тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлж ажиллана.

3.2.7 **Үнэнч байдлыг эрхэмлэх:** Төрийн албандаа ямагт чин сэтгэлээс өөриймсөг хандаж, албан үүргээ аль болох үр бүтээлтэй, илүү чанартай гүйцэтгэх талаар санаачилга, идэвх зүтгэл гарган, иргэдэд төрийн үйлчилгээг бүрэн дүүрэн үзүүлэх талаар боломжтой бүх нөөц бололцоог дүүрэн ашиглаж ажиллана.

3.2.8 **Шуурхай байдлыг эрхэмлэх:** Газрын үйл ажиллагааг явуулахад бусдад элдэв чирэгдэл учруулахгүй байж, ажлын цагийг бүрэн дүүрэн ашиглаж, ялангуяа иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтэд нэн анхааралтай хандаж, боломжтой хамгийн бага хугацаанд шийдвэрлэн хариу өгөх хэмжээнд ажлаа зохион байгуулна.

3.2.9 **Хариуцлага, ил тод байдлыг эрхэмлэх:** Хууль тогтоомжийн хүрээнд мэдээллийн ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан, ажилдаа эзэн болж түүнийхээ гүйцэтгэлийн үр дүнг биечлэн хариуцна.

3.2.10 **Бүтээлч байдлыг эрхэмлэх:** Хариуцсан ажлынхаа чиглэлээр шинийг эрэлхийлэх, шинэ ололт амжилтыг ажилдаа нэвтрүүлнэ.

3.2.11 **Багийн ажиллагааг эрхэмлэх:** Бусдыг хүлээн зөвшөөрч цаг ямагт багийн ажиллагааг эрхэмлэн ажиллана.

3.3.Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаа нь дор дурьдсан тэргүүлэх чиглэлтэй байна.

3.3.1 Орон нутгийн өмчийн удирдлагыг хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх

3.3.2 Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, тайлагнах,

3.4 Газрын үйл ажиллагааны стратеги зорилтууд:

Газар нь өөрийн чиг үүрэг, эрхэм зорилгоо хангахын тулд стратегийн дараах зорилтыг дэвшүүлж байна.

Стратегийн зорилт 1.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, дотоод үйл ажиллагааны хяналтыг сайжруулах

Стратегийн зорилт 2.

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хянах

Стратегийн зорилт 3.

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, орон нутгийн өмчийн ашиглалтад хяналт тавьж түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах

Стратегийн зорилт 4.

Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох

Стратегийн зорилт 5.

Засгийн газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан жагсаалтын дагуу хувьчлах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг тайлагнах

Стратегийн зорилт 6.

Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох шийдвэрийн төсөл, хэрэгжүүлэх удирдамжийн төслийг батлуулах, гүйцэтгэлд хяналт тавих

Стратегийн зорилт 7.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах, шилжүүлэх санал, захиалгыг хянаж, шийдвэрлүүлэх, шинээр авах шийдвэр гаргах

Стратегийн зорилт 8.

Худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах

Стратегийн зорилт 9.

Ерөнхий гэрээг байгуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

Стратегийн зорилт 10.

Худалдан авах ажиллагааны талаарх мэдээ, мэдээллэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг олон нийтэд мэдээллэх

Стратегийн зорилт 11.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах захиалагч байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих, захиалагч болон тендерт оролцогчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сургалт суртачилгаа зохион байгуулах,

Стратегийн зорилт 12.

Худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, саналаа Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх

Стратегийн зорилт 13.

Төрийн худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын хүний нөөцийг хөгжүүлэх, худалдан авах ажиллагаа зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжийг үе шаттайгаар шинэчлэх,

Стратегийн зорилт 14.

Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, төрийн албан хаагчдын ажлын үр нөлөө, ур чадвар, чадавхийг бэхжүүлэх зарчмыг баримтлан, байгууллагын өмнө тавигдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх мэргэшсэн, чадварлаг аппарат бүрдүүлэх

Стратегийн зорилт 15.

Худалдан авах ажиллагаанд оролцож буй төрийн албан хаагч, албан тушаалтан, аж ахуйн нэгжүүд хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зөрчил гаргасан тухай бүрт нь нотлох баримтын хамтаар Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх

Стратегийн зорилт 16.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх гэрээний үүргээ биелээгүй аж ахуйн нэгжийн зөрчлийг бүртгэн авч, “тендерт орох эрхээ хязгаарлуулсан” этгээдийн бүртгэлд хамруулахаар Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал хүргүүлэх

Стратегийн зорилт 17

Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгох, мэдээллийн сүлжээ, системийн найдвартай ажиллагаа, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах

Стратегийн зорилт 18.

Шилэн дансны нэгдсэн нэгдсэн мэдээллийн системд заавал нийтлэх мэдээллийг хууль журманд заасан хугацаанд оруулах

Стратегийн зорилт 19.

Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дүрмийн төсөл боловсруулан батлуулах, бизнес төлөвлөгөөг хянаж, арга зүйн удирдлага зөвлөмжөөр хангах, хэрэгжилтэнд хяналт тавьж холбогдох дүгнэлт шийдвэрийг аймгийн ИТХ-д хэлэлцүүлэх

Стратегийн зорилт 20.

Байгууллагын архив, албан хэрэг, хөтлөлтийг хууль, журам, стандартын дагуу удирдах, хэрэгжүүлэх

Стратегийн зорилт 21.

Байгууллагын санхүү, төсөв, биет хөрөнгийг үр ашигтай удирдах

3.5 Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Стратегийн зорилт	№ (код)	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт
1.Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, дотоод үйл ажиллагааны хяналтыг сайжруулах	1.1	Хууль, төрийн болон орон нутгийн удирдлагын урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг, Улсын их хурлын болон Засгийн газрын тогтоол, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг тус тус өөрийн ба харъяа байгууллагуудын хэмжээнд хангах ажлыг зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг аймгийн хэмжээнд нэгтгэн улирал бүрийн дараа сарын 1-ний өдрөөс өмнө холбогдох байгууллагад тайлагнасан байх	Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн холбогдох заалтууд бүрэн хэрэгжиж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд тайлагнасан байх
	1.2	Өөрийн байгууллага болон харъяа байгууллагуудын үйл ажиллагааны дотоод хяналт, шалгалтыг тогтмолжуулж, улирал бүрийн дараа сарын 10-ны өдрөөс өмнө дотоодын хяналтын тайланг газрын захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, жил, улиралын тайланг холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлсэн байх	Дотоод хяналт, шалгалтыг харъяа байгууллага болон өөрийн байгууллагад тогтмол зохион байгуулсан байх, үр дүнг хугацаанд нь тайлагнасан байх
	1.3	Төрийн бодлого, хууль тогтоомжид нийцүүлэн өмчийн болон худалдан авах ажиллагааны чиглэлээр орон нутагт баримтлах бодлогын баримт бичиг, дүрэм журмын төслийг боловсруулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах	Шаардлагатай бодлогын баримт бичиг, дүрэм, журмыг батлуулсан байх
	1.4	Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг хангах ажлын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах хэрэгжилтийг хангаж, жилийн бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-т тайлагнах	Төлөвлөгөө 90-ээс доошгүй хувийн хэрэгжилтэй биелсэн байх
2.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт,	2.1	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, чанар чансаа, техникийн тодорхойлолтыг нотлох мэдээллийг өмчийн удирдлагыг	Орон нутгийн эд хөрөнгийн бүртгэл, хяналт сайжирч,

хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хянах	мэдээлэлжүүлэх цахим системд бүрэн оруулах, хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр шинэчилэх, системийн хөтлөлтийг тогтмол хянах үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүн, үр нөлөөг хагас бүтэн жилийн сүүлийн сарын 25-ны өдрөөс өмнө газрын захиргааны зөвлөлийн хуралд хэлэлцүүлж, мэдээ тайланг тогтоосон хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлж, тайлагнасан байх	өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системийн дүүргэлт 100 хувьд хүрсэн байх
2.2	Орон нутгийн өмч хөрөнгийг эзэмшиж буй хуулийн этгээд, иргэнтэй өмч эзэмшлийн гэрээг байгуулж, жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны өдрөөс өмнө урьд оны гэрээний биелэлтийг дүгнэж, үр дүнг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид, Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанд тус тус хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулсан байх,	Орон нутгийн өмчийн эд хөрөнгө бүрийг эзэнжүүлж, өмч эзэмших ашиглах гэрээг байгуулж дүгнэж хэвшсэн байх
2.3	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдэд шаардлагатай хөрөнгийн хэрэгцээ, түүний хүчин чадлыг оновчтой тодорхойлох, хөрөнгө бэлтгэх төлөвлөлтийг аймгийн хэмжээнд нэгдсэн бодлогоор зохицуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг аймгийн ИТХ, Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанд жил бүрийн 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулсан байх	Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шаардлагатай эд хөрөнгийн хэрэгцээг оновчтой тодорхойлох, хөрөнгийн үнэлгээ тооллогыг хууль журмын дагуу зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх
2.4	Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн хувийн хэргийн хөтлөлтөд хяналт тавих	Нийт хуулийн этгээдийн 30-аас доошгүй хувьтай тэнцэх хэсэгт хяналт шалгалт зохион байгуулсан байх
2.5	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, үнэлэлт дүгнэлт өгөх, орон нутгийн өмчийн эдийн засаг, нийгмийн үр өгөөж, үнэ цэнийг хуулийн этгээд нэг бүрт тооцон, өмчийн өгөөж үнэ цэнийг алдагдуулсан, өмч эзэмшлийн гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн хуулийн этгээдийн удирдлагад хариуцлага тооцох саналыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлсэн байх	Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмч хөрөнгийн эдийн засаг нийгмийн үр өгөөж нэмэгдсэн байна.
2.6	Улс, орон нутгийн төсөв, хандив тусламжийн хөрөнгөөр бэлтгэсэн өмч хөрөнгө бүрт чанарын баталгааны хугацаанд хяналт тавих, чанарын баталгааг чөлөөлөх журмыг батлуулж, хэрэгжилтийг зохион байуулна.	Журмын хэрэгжилт хангагдсан байх
2.7	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөлийг мэргэжил арга зүйн удирдлага, сургалт, зөвлөмжөөр хангах арга хэмжээг зохион байгуулж, тэдний үйл ажиллагааны үр дүнг үнэлэн, урамшуулах арга хэмжээ авах	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжиж, үйл ажиллагааны үр дүн дээшилсэн байх
2.8	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын байдалд хяналт тавьж,	Тайланд хурлын тогтоолоор

		нэгдсэн тайланг жил бүрийн 12 дугаар сарын эхний 10 хоногт багтаан аймгийн ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлнэ.	үнэлэлт, дүгнэлт өгсөн байна.
3. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, орон нутгийн өмчийн ашиглалтад хяналт тавьж түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах	3.1	Улс, орон нутгийн төсөв, хандив тусламжийн хөрөнгөөр бэлтгэсэн өмч хөрөнгө бүрийг данс бүртгэлд тусгах, эзэмшигчийг тогтоох, хадгалалт, хамгаалалтын горимыг мөрдүүлэх	Улс, орон нутгийн төсөв, хандив тусламжийн хөрөнгөөр бэлтгэсэн өмч хөрөнгийн нэгдсэн мэдээллийн сантай болсон байх
	3.2	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг тоолох, чанар байдлыг үнэлэх ажиллагааг удирдлагаар хангаж, тооллогын дүн мэдээг нэгтгэж тайлагнах	Орон нутгийн өмчит нийт хуулийн этгээдийн өмч хөрөнгө тооллогод хамрагдсан байна.
	3.3	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа өмч, хөрөнгийн мэдээ тайланг нэгтгэж, аймгийн ИТХ, Засаг даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэх	Тайлан мэдээг хууль журманд заасан хугацаанд хүргүүлсэн байна.
	3.4	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн захиалгыг үндэслэн хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл олгох	Шаардлагатай хөрөнгийг бэлтгэсэн байх
	3.5	Орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, захиран зарцуулалтын байдалд хийх хяналт шалгалтыг дангаараа болон холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, зөрчил, дутагдлыг арилгуулах, илүүдэлтэй өмч хөрөнгийн судалгааг гаргаж, шийдвэрлэх, дутагдуулсан, үрэгдүүлсэн, зүй бусаар зарцуулсан, эвдэлсэн хөрөнгийг нөхөн төлүүлэх, хөрөнгийн маргаантай асуудлыг хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх, хөрөнгийн маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх тохиолдолд өмчлөгчийг төлөөлөн нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох,	Орон нутгийн өмчийн захиран зарцуулалтанд тавих хяналтыг жилд нийт орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 30-аас доошгүй хувьд зохион байгуулсан байна.
	3.6	Орон нутгийн өмчтэй холбоотой лавлагаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжид олгох үйл ажиллагааг зохион байгуулна.	Лавлагаа, тодруулга, мэдээлэл хүссэн иргэн аж ахуйн нэгжийн хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн байна.
	3.7	Орон нутгийн өмчийн хөрөнгийн нийгэм, эдийн үр өгөөжийг дээшлүүлэх, санхүү, тайлагналтыг боловсронгуй болгох талаар зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, үр дүнг аймгийн ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлж, холбогдох дүгнэлт шийдвэрийг гаргуулсан байх	ИТХ-аас дүгнэлт шийдвэр гарсан байх
	3.8	Орон нутгийн өмчийн илүүдэлтэй хөрөнгийг түрээслэх, дуудлагаар худалдах үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, холбогдох гэрээг хуульд нийцүүлэн байгуулах, орлогыг төвлөрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Орон нутгийн өмчийн дуудлагын худалдааны болон түрээсийн орлогыг 100 төсөвт

			төвлөрүүлсэн байна..
	3.9	Улс, орон нутгийн төсөв, хандив тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авах Улсын комисс, ажлын хэсгийн бүрэлдхүүнд ажиллах	Хөрөнгийг бүртгэлжүүлэх, чанар байдлыг тодорхойлж, өмчийн удирдлыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байна.
4.Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох	4.1	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн бүтээгдхүүн үйлчилгээний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг хийж, ирээдүйн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хандлагад нийцүүлэн зорилтот түвшинг тодорхойлж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах, зорилтот түвшингийн биелэлтийг дүгнэж, жил бүр аймгийн ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлсэн байна.	Зорилтот түвшингийн хэрэгжилт 85-аас доошгүй хувийн хэрэгжилттэй байна.
	4.2	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид шаардлагатай техник зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Хөрөнгө оруулалтын хэрэгцээг оновчтой тодорхойлсон байх
	4.3	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг тогтоон хувь нийлүүлэгчдийн хурлаар батлуулах, төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих, үр дүнг аймгийн ИТХ-ын хуралдаанд жил бүр тайлагнах	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой бүх хуулийн этгээдийн ТУЗ-ын зардал батлагдсан, зардал хэтрүүлээгүй байх
	4.4	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж холбогдох дүгнэлт шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлж батлуулах.	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой бүх аж ахуйн нэгжийн тайланг хэлэлцүүлсэн байх
	4.5	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ноогдол ашгийн төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд хэлэлцүүлэн батлуулах, гүйцэтгэлийг тайлагнах	Ноогдол ашгийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангасан байх
5.Засгийн газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан жагсаалтын дагуу хувьчлах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг тайлагнах	5.1	Орон сууц хувьчлах аймгийн товчоог байгуулах шийдвэрийн төслийг боловсруулан батлуулж, уг товчоог мэргэжил арга зүйн удирдлага, зөвлөмжөөр хангаж, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг аймгийн засаг даргын зөвлөлийн хурал, аймгийн ИТХ-ийн тэргүүлэгчдийн хуралд хэлэлцүүлж, холбогдох шийдвэр гаргуулах	Орон сууц хувьчлалын товчоог байгуулан үйл ажиллагааг тогтмолжуулсан байх
	5.2	Хувьчлах орон нутгийн өмчийн жагсаалтыг Засгийн газарт хүргүүлэн зөвшөөрөл авах, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанд хэлэлцүүлж батлуулан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын удирдлага хяналт дор хувьчлах ажлыг зохион байгуулах	Жил бүр хувьчлах хөрөнгийн жагсаалтыг гаргаж хууль журмын дагуу батлуулсан байх

	5.3	Өмч хувьчлалын ажлын тайланг жил бүр аймгийн ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тайлагнана.	Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.
6.Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох шийдвэрийн төсөл, хэрэгжүүлэх удирдамжийн төслийг батлуулах, гүйцэтгэлд хяналт тавих	6.1.	Орон нутгийн өмчийн төлөөлөгчөөр ажиллах төлөөлөгч нь тухайн салбарын мэргэшсэн албан төрийн албан хаагч, иргэн байх бөгөөд түүнийг сонгон шалгаруулалтаар сонгож, хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлэн томилно.	Өмчийн төлөөлөгчийн хуулийн хугацаанд томилуулсан байх
	6.2	Орон нутгийн өмчийн төлөөлөгчийг хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцох бүрт аймгийн засаг даргаас баталсан удирдамжийг өгч, удирдамжийн гүйцэтгэлд хяналт тавина.	Орон нутгийн өмчийн төлөөлөгч нь хуралд оролцох бүртээ удирдамж авсан байна.
	6.3	Аймгийн Засаг даргаас удирдамж аваагүй эсхүл удирдамжийг хэрэгжүүлэхээс татгалзсан орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилсон эрх бүхий этгээдийн шийдвэрээр эргүүлэн татуулах арга хэмжээ авах	Орон нутгийн өмчийн төлөөлөгчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн байх
	6.4	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилуулах саналыг төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлж, нарийн бичгийн даргыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, түүний үйл ажиллагааны үр дүнг үнэлж, тайлагнана.	
7.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах, шилжүүлэх санал, захиалгыг хянаж, шийдвэрлүүлэх, шинээр авах шийдвэр гаргах	7.1	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг худалдах, актлах шүлжүүлэх тухай эзэмшигч байгууллагын саналыг хянаж, шийдвэрийн төслийг боловсруулж холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх	Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөл, ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн байх
	7.2	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг худалдах, актлах, шүлжүүлэх тухай шийдвэрийн биелэлтийг хангуулж, гүйцэтгэлийн үр дүнг тухай бүр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад тайлагнасан байх	Эд хөрөнгийг худалдах, актлах шүлжүүлэх тухай шийдвэрийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.
8.Худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах	8.1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллагууд болон тус газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг нэгтгэн аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд хэлэлцүүлж, батлуулах, төлөвлөгөөний төслийг 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө Сангийн яаманд хүргүүлсэн байх	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөл батлагдан холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.
	8.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллагууд болон тус газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хянан нэгтгэж, аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан Улс, орон нутгийн төсөв батлагдсан өдрөөс хойш 10 өдрийн дотор Сангийн яам, Засгийн газрын ХАА-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус хүргүүлсэн байна.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлан, хуульд заасан хугацаанд багтаан холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн байна.
	8.3	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Улс, орон нутгийн төсөв батлагдсан өдрөөс	Төсвийн ерөнхийлөн

	хойш 1 сарын дотор төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, үндэсний өдөр тутмын сонинд тус тус нийтэлэх, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, иргэдэд танилцуулах хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан байх	захирагчийн ХАА-ны төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтэлсэн байх
8.4	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох үнэлгээний хороог төсөл арга хэмжээний жагсаалт батлагдсан өдрөөс хойш 20 хонгийн дотор байгуулж, тендерийн баримт бичгийг боловсруулж захиалагчаар батлуулсан байх	Үнэлгээний хороог байгуулж, тендерийн баримт бичгийг батлуулсан байна.
8.5	Төсөл арга хэмжээ бүрийн ХАА-ны төлөвлөгөөг захиалагчаар батлуулж, тендер шалгаруулалтын тендерийн урилга, захиалагчийн тендерийн баримт бичгийг төрийн ХАА-ны цахим системд нийтлэх	Хуулийн хэрэгжилт хангагдсан байх
8.6	Тендерийн нээлт, үнэлгээг хууль журмын дагуу зохион байгуулж, тайлагнах	Хууль, журмын хэрэгжилт хангагдсан байх
8.7	Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт нь холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах, захиалагчид холбогдох зөвлөмжийг хүргүүлэх	Захиалагчийн хуульд заасан эрх үүрэг хэрэгжсэн байх
8.8	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогч нарт шалгарсан шалгараагүй мэдэгдлийг нэгэн зэрэг хүргүүлэх, шалгарсан оролцогчийн тендерт санал болгосон гэрээний ерөнхий, тусгай нөхцлийг тусгасан гэрээний төслийг боловсруулж, захиалагч, гүйцэтгэгчээр батлуулах,	Хуулийн хэрэгжилт хангагдсан байх
8.9	Захиалагчийн хяналт хэрэгжүүлэхэд чиг үүргийн хувьд оролцох Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн ЗДТГ, Инженерийн хангамжийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, Төрийн бус байгууллага, бусад байгууллагатай хамтран ажиллах санамж, гэрээг байгуулан дүгнэж, үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлсэн байх	Санамж, гэрээг байгуулан дүгнэсэн байна.
8.10	Гэрээний хэрэгжилтийг удирдах чиг үүрэг бүхий төслийн багийг байгуулах, гэрээний хэрэгжилтийг удирдах, ХАА-ны хэрэгжилт, захиалагчийн хяналтын гүйцэтгэлийн тайланг нэгтгэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, тэдгээрийн үр дүнг захиалагч болон холбогдох төрийн байгууллагад тайлагнана.	Худалдан авах ажиллагаа бүрэн хэрэгжсэн байх
8.11	Улс, орон нутгийн төсөв, хандив тусламжийн хөрөнгөөр санхүүжихээр баталсан төсөл арга хэмжээ бүрийн худалдан авах ажиллагааны хавтаст хэргийг хууль журманд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж, тендер шалгаруулалт дууссан, гэрээ дүгнэсэн өдрөөс хойш 10 өдөрт багтаан баримт бичиг нягтлан шалгах комисс, дотоод хяналтын	Хавтаст хэргийг хууль журмын дагуу бэлтгэж, тогтоосон хугацаанд байгууллагын архивт хүлээлгэн өгсөн байх.

		багт, жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө төрийн аудитын байгууллагад шалгуулан байгууллагын архивт хүлээлгэн өгсөн байна.	
	8.12	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллагуудын тендер шалгаруулалттай холбоотой гомдол маргааны хянаж, зөвлөмж өгөх замаар гомдол маргааныг шийдвэрлэх	Гомдол маргаан шийдвэрлэгдсэн байх
	8.13	Улс, орон төсөв, хандив тусламжийн хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан төсөл арга хэмжээ бүрийн тендер шалгаруулалтын ерөнхий мэдээлэл болон шилэн дансны хуульд заасан мэдээллийг тогтоосон хугацаа (тендерийг үнэлж, оролцогчдод мэдэгдэл хүргэсэн өдрөөс хойш 7 хонгийн дотор)-нд шилэн дансны нэгдсэн мэдээллийн систем, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон өөрийн байгууллагын цахим хуудсанд нийтэлсэн байх	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангасан байх
	8.14	Захиалагчийн хяналтын зардалын төлөвлөлт, зарцуулалтын гүйцэтгэлийг нэгтгэн аймгийн санхүү, хяналт дотоод аудит, төрийн аудитын байгууллагаар хянуулан, гарсан зөрчил, дутагдлыг арилгаж, нэгдсэн тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлж, үнэлэлт дүгнэлт авсан байх	
	8.15	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллагуудын болон тус газрын худалдан авах ажиллагааны сар, улирал, жилийн тайланг хууль, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу нэгтгэн сар бүрийн 26-ны өдрөөс өмнө аймгийн ИТХ, Засаг дарга, эрхээ шилжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын ХАА-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн ХАА-ны нэгдсэн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус тайлагнана.	Худалдан авах ажиллагааны тайланг хууль, журмаар тогтоосон хугацаанд холбогдох байгууллагад тайлагнасан байх
9. Ерөнхий гэрээг байгуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	9.1	Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний нэр төрөл тоо хэмжээг тогтоож аймгийн ИТХ-ын шийдвэрээр батлуулах	Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний нэр төрөл тоо хэмжээ батлагдсан байх
	9.2	Ерөнхий гэрээгээр бараа, үйлчилгээ нийлүүлэх этгээдийг сонгож, гэрээ байгуулах, гэрээний гүйцэтгэлд хяналт тавих, гэрээг дүгнэх, холбогдох байгууллагад тайлагнах	Хууль, журмын дагуу зохион байгуулсан байх
10. Худалдан авах ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг олон нийтэд мэдээллэх	10.1	Тендер шалгаруулалтын зар, үр дүнгийн мэдээлэл, гэрээний хэрэгжилтийн явцын болон эцсийн гүйцэтгэлийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр мэдээлсэн байх	Мэдээллийг хууль журманд заасан мэдээллийн хэрэгсэлд нийтэлж олон нийтэд ил тод мэдээлсэн байх
	10.2	Улс, орон нутгийн төсөв, хандив тусламжийн хөрөнгөөр санхүүжихээр тухайн жилд	Төсөл арга хэмжээнээс ашиг

		багт, жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө төрийн аудитын байгууллагад шалгуулан байгууллагын архивт хүлээлгэн өгсөн байна.	
	8.12	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллагуудын тендер шалгаруулалттай холбоотой гомдол маргааны хянаж, зөвлөмж өгөх замаар гомдол маргааныг шийдвэрлэх	Гомдол маргаан шийдвэрлэгдсэн байх
	8.13	Улс, орон төсөв, хандив тусламжийн хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан төсөл арга хэмжээ бүрийн тендер шалгаруулалтын ерөнхий мэдээлэл болон шилэн дансны хуульд заасан мэдээллийг тогтоосон хугацаа (тендерийг үнэлж, оролцогчдод мэдэгдэл хүргэсэн өдрөөс хойш 7 хонгийн дотор)-нд шилэн дансны нэгдсэн мэдээллийн систем, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон өөрийн байгууллагын цахим хуудсанд нийтэлсэн байх	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангасан байх
	8.14	Захиалагчийн хяналтын зардалын төлөвлөлт, зарцуулалтын гүйцэтгэлийг нэгтгэн аймгийн санхүү, хяналт дотоод аудит, төрийн аудитын байгууллагаар хянуулан, гарсан зөрчил, дутагдлыг арилгаж, нэгдсэн тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлж, үнэлэлт дүгнэлт авсан байх	
	8.15	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллагуудын болон тус газрын худалдан авах ажиллагааны сар, улирал, жилийн тайланг хууль, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу нэгтгэн сар бүрийн 26-ны өдрөөс өмнө аймгийн ИТХ, Засаг дарга, эрхээ шилжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын ХАА-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн ХАА-ны нэгдсэн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус тайлагнана.	Худалдан авах ажиллагааны тайланг хууль, журмаар тогтоосон хугацаанд холбогдох байгууллагад тайлагнасан байх
9.Ерөнхий гэрээг байгуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	9.1	Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний нэр төрөл тоо хэмжээг тогтоож аймгийн ИТХ-ын шийдвэрээр батлуулах	Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний нэр төрөл тоо хэмжээ батлагдсан байх
	9.2	Ерөнхий гэрээгээр бараа, үйлчилгээ нийлүүлэх этгээдийг сонгож, гэрээ байгуулах, гэрээний гүйцэтгэлд хяналт тавих, гэрээг дүгнэх, холбогдох байгууллагад тайлагнах	Хууль, журмын дагуу зохион байгуулсан байх
10. Худалдан авах ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг олон нийтэд мэдээллэх	10.1	Тендер шалгаруулалтын зар, үр дүнгийн мэдээлэл, гэрээний хэрэгжилтийн явцын болон эцсийн гүйцэтгэлийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр мэдээлсэн байх	Мэдээллийг хууль журманд заасан мэдээллийн хэрэгсэлд нийтэлж олон нийтэд ил тод мэдээлсэн байх
	10.2	Улс, орон нутгийн төсөв, хандив тусламжийн хөрөнгөөр санхүүжихээр тухайн жилд	Төсөл арга хэмжээнээс ашиг

		батлагдсан төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн чанар байдлын талаар ашиг хүртэгч иргэдийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэсгээс сэтгэл ханамжийн судалгаа авч ИТХ, засаг даргад дараа жилийн 2 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө тайлагнах	хүртэгч иргэдийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэсгээс сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг тайлагнасан байх
11. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах захиалагч байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих, захиалагч болон тендерт оролцогчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сургалт сурталчилгаа зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх	11.1	Харъяа захиалагч байгууллагуудын тендер шалгаруулалт, худалдан авах ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт, шалгалт хийж, алдаа зөрчлийг арилгуулах, үүсч болзошгүй эрдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, аймгийн ИТХ, Засаг даргад тайлагнах	Харъяа байгууллагуудын 50-аас доошгүй хувьтай тэнцэх хэсгийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн байна.
	11.2	Харъяа захиалагч байгууллага болон тендерт оролцогчдод худалдан авах ажиллагааны хууль тогтоомж, холбогдох бусад хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, удирдлагаар хангах, сургалт сурталчилгаа зохион байгуулах ажлыг жилд 2-оос доошгүй удаа хийж, үр дүнг аймгийн Засаг даргад тайлагнасан байх	Захиалагч, тендерт оролцогчдод хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулсан байх
12. Худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, саналаа Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх	12.1	Аймгийн хэмжээнд худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан үр дүнг нэгтгэх, дээрх хууль тогтоомжийн талаар иргэд олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулж, санал дүгнэлтээ Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн байна.	Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд үүсч байгаа ололт, амжилт, тулгамдсан асуудлыг судалдсан байх
13. Төрийн худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын хүний нөөцийг хөгжүүлэх, худалдан авах ажиллагаа зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжийг үе шаттайгаар шинэчлэх,	13.1	Төрийн худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын хүний нөөцийг хөгжүүлэх, хэрэгжилтийг хангаж, тайлагнах	Хөтөлбөр батлагдсан, хэрэгжилт 85 хувиас доошгүй хувийн биелэлттэй байх
	13.2	Газрын удирдлагын мэдээллийн систем, өмчийн бүртгэл хяналт, худалдан авах ажиллагааны процесст мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлэх	Хөтөлбөр батлагдсан, хэрэгжилт 85 хувиас доошгүй хувийн биелэлттэй байх
14. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, төрийн албан хаагчдын ажлын үр нөлөө, үр чадвар, чадавхийг бэхжүүлэх зарчмыг баримтлан, байгууллагын өмнө тавигдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх мэргэшсэн,	14.1	Иргэнийг төрийн албанд томилох, чөлөөлөх ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах зэрэг асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, үр чадвар, туршлага, ёс суртахуун, харьцаа хандлага, ажлын үр дүнд тулгуурладаг тогтолцоог бий болгоно.	Чадахуйн зарчим хэрэгжсэн байна.
	14.2	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, байгууллагын ажиллах хүч, мэргэжилтний хэрэгцээг тодорхойлох	Хүний нөөцийн судалгаа хийсэн байх

чадварлаг бүрдүүлэх	аппарат	14.3	Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг жил бүр шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган, 12 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө тайлагнах	Хөтөлбөрийн хэрэгжилт 80 хувиас доошгүй хувийн хэрэгжилттэй байна.
		14.4	Төрийн албан хаагч бүр өөрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, мэргэжлийн түвшинг 12 дугаар сарын 20-ны өдрөөс өмнө төсвийн шууд захирагчаар үнэлүүлж, холбогдох үнэлгээ дүгнэлт авсан байна.	Хугацаандаа хэрэгжсэн байна.
		14.5	Төрийн албан хаагч нь хууль тогтоомж, болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, өмнөх оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө батлуулж, дараа оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлэн тайлагнана..	Гүйцэтгэлийн төлөвлөгөө 85-аас доошгүй хувийн хэрэгжилттэй байна.
		14.6	Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан баталж, жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 85 хувиас доошгүй хувийн биелэлттэй байна.
		14.7	Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, хувь хүний болон төрийн нууц хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх батламж гэрээг төрийн албан хаагч бүр байгууллагын захиргаатай байгуулж, жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө батламж гэрээг дүгнүүлсэн бхйна.	Төрийн албан хаагч бүрийн батламж гэрээг дүгнэж, газрын захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үнэлэлт дүгнэлт өгсөн байна.
		14.8	Төрийн албан хаагч бүр төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмээр хүлээсэн үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлж, жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө ёс зүйн дүрмийн зүйл заалт бүрийг хэрхэн хэрэгжүүлж ажилласнаа тайлагнана.	Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг газрын захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үнэлэлт дүгнэлт өгсөн байна.
15.Худалдан авах ажиллагаанд оролцож буй төрийн албан хаагч, албан тушаалтан, аж ахуйн нэгжүүд хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зөрчил гаргасан тухай бүрт нь нотлох баримтын хамтаар Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх	15.1	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн худалдан авах ажиллагааны хэрэгжилт, санхүүжилтийн гүйцэтгэл, үнэлгээний хороо, төслийн багийн шийдвэр зэрэг нь баримт бичгүүдийг шалган, үнэлэлт дүгнэлт гаргах	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 50-аас доошгүй хувьтай тэнцэх хэсгийн шаардлагатай баримт бичгийг шалган үнэлэлт дүгнэлт гаргасан байх	
		15.2	Хууль заасан эрх үүргээ хэрэгжүүлээгүй, хууль, журмыг зөрчсөн нь тогтоогдсон аж ахуйн нэгж байгууллага, үнэлгээний хорооны болон төслийн багийн гишүүдийн талаарх мэдээллийг нотлох баримтын хамтаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлсэн байх	Зөрчил илэрсэн тухай бүр холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлсэн байх

16. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх гэрээний үүргээ биелээгүй аж ахуйн нэгжийн зөрчлийг бүртгэн авч, "тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл"-д хамруулахаар санал хүргүүлэх	16.1	Улс, орон нутгийн төсвийн болон хандив тусламжийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх гэрээний үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, тендертээ хуурамч баримт бичиг ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийг "тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл"-д бүртгүүлэхээр Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлэх	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт хангагдана.
17. Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгох, мэдээллийн сүлжээ, системийн найдвартай ажиллагаа, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах	17.1	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмыг мэдээллийн технологийн хөгжилтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, батлуулж, мөрдөн ажиллана.	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам батлагдан, хэрэгжсэн байх
	17.2	Мэдээлэл боловсруулах хэрэгсэл, холбогдох дэд бүтцийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдал, тасралтгүй ажиллагаа, найдвартай байдалд гаднаас болон дотоодоос учирч болох халдлага, аюул заналаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгсэл, үйл ажиллагааны төлөвлөлтийг бий болгох, хор хохирол эрсдэл учирсан гэж үзвэл урьдчилан бэлтгэсэн заавар, журмын дагуу нэн даруй засаж, сэргээх, хариу арга хэмжээ авах тогтолцоо бий болгосон байна.	Мэдээллийн технологийн аюулгүй байдал бүрэн хангагдсан байна.
18. Шилэн дансны нэгдсэн нэгдсэн мэдээллийн системд заавал нийтлэх мэдээллийг хууль журманд заасан хугацаанд оруулах	18.1	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны нэгдсэн мэдээллийн сан, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон байгууллагын цахим хуудсанд хуулиар тогтоосон хугацаанд нийтэлсэн байх	Шилэн дансны хуульд заасан мэдээллийг холбогдох мэдээллийн хэрэгсэлд 100 хувь нийтэлсэн байх
19. Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дүрмийн төсөл боловсруулан батлуулах, бизнес төлөвлөгөөг хянаж, арга зүйн удирдлага зөвлөмжөөр хангах, хэрэгжилтэнд хяналт тавьж холбогдох дүгнэлт шийдвэрийг аймгийн ИТХ-д хэлэлцүүлэх	19.1	Орон нутгийн өмчит өмчийн оролцоотой хуулийн этгээдийг татан буулгах, шинээр байгуулах, нийлүүлэх, нэгтгэх шийдвэрийн төслийг боловсруулж батлуулах	Хууль журманд нийцүүлэн
	19.2	Орон нутгийн өмчит өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дүрмийг шинэчлэх, өөрчлөх төслийг боловсруулж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулах, дүрмийн хяналтыг хэрэгжүүлж тайлагнах	Хуулийн хэрэгжилт хангах арга хэмжээг хэрэгжүүлсэн байх
	19.3	Орон нутгийн өмчит өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж, холбогдох дүгнэлт шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлж, зохих шийдвэрийг гаргуулах	Компанийн үйл ажиллагааны үр дүн, орон нутгийн өмчийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлсэн байх

20. Байгууллагын архив, албан хэрэг, хөтлөлтийг хууль, журмын дагуу удирдах	20.1	Төрийн албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу хэрэгжүүлэх, архив, бичиг хэрэгт цахим программ хангамж нэвтрүүлэх	Албан хэрэг стандартын дагуу хөтлөгдсөн байх
	20.2	Ирсэн бичгийг хүлээн авах, ангилах, бүртгэх, холбогдох ажилтанд шилжүүлэх, баримт бичгээр тавьсан асуудлын шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, үр дүнг удирдлагад танилцуулах, шийдвэрлэх хугацаа хэтэрсэн баримт бичиг, өргөдөл гомдлын мэдээг гаргах, дотооддоо боловсруулсан болон гадагш явуулах баримт бичгийг стандартын дагуу зохиож, бүрдүүлсэн эсэхэд хяналт тавих, явуулах баримт бичгийг хүлээн авч, бүрдлийг шалгаж бүртгэх, хаяглаж, илгээх, өргөдөл гомдлын мэдээ тайланг гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд үүсч хөтлөгдсөн баримт бичиг, мэдээллийг ангилах, төрөлжүүлэх, мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.	Төрийн албан хэрэг хөтлөлтийг зааварын дагуу зохион байгуулсан байх
	20.3	Захиргааны актад хувийн хэрэг хөтлөх, архивын баримт бичгийн тооллогыг 3 жилд нэг удаа зохион байгуулж, тайлагнах	Төрийн албан хэрэг хөтлөлтийг зааврын дагуу хэрэгжүүлсэн байх
	20.4	Архивын баримт бичгийн цахим мэдээллийн сан бүрдүүлэх, баримт бичгийн эргэлтийн мэдээг хагас бүтэн жилээр гарган тайлагнах	Баримт бичгийг цахим архивт хадгалсан байх
	20.5	Архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалтын дүрэм, журмыг мөрдөн ажиллаж, тайлагнах	Журам хэрэгжсэн байх
	20.6	Төрийн албан хаагчийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлуулах, мөрдөх, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бичгийг ББНШК-д хянуулан байгууллагын архивт хүлээлгэн өгөх, авах, үр дүнг тайлагнах	Төрийн албан хаагч бүр өөрийн баримт бичгийг архивт хүлээлгэн өгсөн байх
	20.7	Байгууллагын архивын зарим баримт бичгийг аймгийн архивт хүлээлгэн өгөх	Хууль журамд заасан баримт бичгийг аймгийн архивт хүлээлгэн өгөх
21. Байгууллагын санхүү, төсөв, биет хөрөнгийг удирдах	21.1	Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд багтаан тайлагнах	Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг сар, улирал бүр мэдээлсэн байна.
	21.2	Байгууллагын төсвийн төслийг боловсруулж, батлуулах	Хуулийн хугацаанд багтаан төсвийн төслийг төсвийн ерөнхийлөн захирагчид өргөн барьсан байх
	21.3	Биет хөрөнгийн нөөцийг зохистой ашиглах, тайлагнах	Хөрөнгийн тайланг тогтоосон хугацаанд гаргаж, хүргүүлсэн байх
	21.4	Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудит, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг ил тод мэдээлэх	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлсэн байх.


Стратеги зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёр үндсэн хэсэгт ангилан авч үзлээ. Үүнд:

1. Үйл ажиллагааг сайжруулах: /Газрын дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа сайжруулан зохион байгуулах/

2. Үйл ажиллагааг шинэчлэх: /Газрын үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах /

3.6 Газрын удирдлага, бүтэц зохион байгуулалт

Газрыг байгуулах, өөрчлөх асуудлыг Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор, бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны дүрмийг аймгийн Засаг даргын захирамжаар батална. Байгууллага дахь зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтын асуудлыг нарийвчлан зохицуулсан дүрмийг Газрын дарга батална. Аймгийн Засаг дарга нь аймгийн орон нутгийн өмчийн газрын даргыг томилж, чөлөөлнө. Аймгийн орон нутгийн өмчийн газрын дарга нь хэлтсийн дарга, албан хаагчдыг томилж, чөлөөлнө. Зохион байгуулалт: Газрын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, дотоод ажлын уялдаа холбоог сайжруулах үүрэг бүхий Захиргааны зөвлөлийн хуралтай байх бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүн, хурлын дэгийг газрын даргын тушаалаар батална



3.7 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүтэц

Хөвсгөл Иргэдийн төөөлөлгчдийн хурлын тэргүүлэгчийн 2017 оны 65 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн өмчийн газар нь 12 орон тоотой байхаар баталсан бөгөөд дарга-1, 2 хэлтэстэй байхаар баталсан байна. Үүнд:

1. Газрын дарга
2. Өмчийн харилцааны хэлтэс
3. Худалдан авах ажиллагааны хэлтэс
4. Захиргаа, санхүүгийн хэсэг

Захиргааны зөвлөл нь: Газрын эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, дотоод ажлын уялдаа холбоог сайжруулах, дотоод хяналтын үр дүнг хэлэлцэж стратеги төлөвлөгөөг сайжруулах үүргийг гүйцэтгэнэ. Тус хурлыг газрын дарга удирдан зохион байгуулна.

3.8 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх дотоод үйл ажиллагааны загвар

- Газрын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэлбэрийн хувьд газрын ажилчид болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах замаар үндсэн бодлогын ажлуудыг хэрэгжүүлнэ. Мөн газрын дотоод үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нарийвчилсан төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, төсвийн шууд захирагчийн төсөв, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах
- Байгууллагыг төлөөлж хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах, байгууллагын үйл ажиллагааны дотоод эрх зүйн орчныг боловсронгуй болгох дүрэм, журам, зааврыг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх, мөрдүүлэх, хяналт тавих
- Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт, шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авах
- Худалдан авах ажиллагааны цахим систем хэрэглэгчдийг чадавхижуулах, мэдээлэл солилцох замаар төрийн байгууллагуудын ажлын уялдаа, холбоог сайжруулах
- Байгууллагын нууц, аюулгүй байдлыг хангах, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ил тод, нээлттэй байдлыг хангах
- Аймгийн удирдлагаас худалдан авах ажиллагааны болон өмчийн харилцааны талаар шийдвэр гаргахад нь зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг хэрэгжүүлэх
- Хэлтэс, хэсгийн төрийн албан хаагчдын манлайллыг дүгнэх, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, мэргэжлийн түвшинд үнэлгээ, дүгнэлт өгөх үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах
- Худалдан авах ажиллагааны болон компанийн засаглалын мэргэшсэн ажилтан бэлтгэх, мэдээллийн сан бүрдүүлэх
- Газрын үйл ажиллагаа, санхүүд дотоод хяналт зохион байгуулж, тайлагнах
- Газрын үйл ажиллагааны чиг үүрэгт хамаарах төлөвлөлтүүдийг гаргах, нэгтгэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг зохион


байгуулах, гүйцэтгэлийн мэдээ тайланг гаргах, нэгтгэх, дээд шатны албан тушаалтан, байгууллагыг мэдээллээр хангах.

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх дотоод үйл ажиллагааны загвар



3.9 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх гадаад үйл ажиллагааны загвар

Схем 3



- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу жил бүрийн худалдан авах ажиллагааны тайлан, төлөвлөгөөг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус хүргүүлнэ.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу орон нутгийн өмчийн тайланг төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт жил бүр хүргүүлж, тайлагнана.
- Аймгийн хэмжээнд худалдан авах ажиллагаа, орон нутгийн өмчийн харилцааны асуудлыг нэгтгэн зохион байгуулж, харъяа сум, байгууллагуудыг мэргэжилийн удирдлага, арга зүйн зөвлөмжөөр хангах замаар хамтран ажиллана.
- Газрын дүрмээр хүлээсэн үүргийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулна.

ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

4.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим:

4.1.1. Газрын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хугацаанд үе шаттайгаар үнэлгээ өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг газрын даргын тушаалаар байгуулан ажиллана.

4.1.2. Газрын стратеги төлөвлөгөөг жил бүрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулах, явцын хяналтыг тогтмол хийх үүргийг хэлтсийн дарга нар хариуцан ажиллана.

4.1.3. Газрын стратеги төлөвлөгөөнд явцын хяналт хийж, бүтэн жилээр биелэлтийг дүгнэх нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлж, удирдлагын үйл явцын үр нөлөөг үнэлж, сайжруулахад оршино.

4.1.4. Урьдчилсан болон нэгтгэн дүгнэх үнэлгээ нь хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүн, үр нөлөөг тогтооход чиглэнэ.

4.1.5. Стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, тодотгох асуудлыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан хяналт, шинжилгээ үнэлгээ хийх ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

4.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй:

4.2.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээ, хугацааг удирдамжаар тодорхойлно.

4.2.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжийг аймгийн засаг дарга дарга батална.

4.2.3 Тайланд хяналт-шинжилгээ хийхдээ хагас бүтэн жилээр гаргасан тайлан, мэдээтэй танилцаж баримт бичгийг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

4.2.4 Бодлогын зорилтын хэрэгжилтийн төвшинг тодорхойлохдоо тавьсан зорилтын гүйцэтгэл тогтоох шалгуур үзүүлэлтийн үр дүнг (Гүйцэтгэл) хүрэх түвшин буюу тавьсан зорилтод (Зорилт) харьцуулж хувиар илэрхийлнэ. (Г/Зх100).

4.2.5 Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй зорилтын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

4.2.5.1 тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр гарч, үр дүн гарсан бол 100 хувь

4.2.5.2 тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч санхүү, зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь (80.0-100.0 хүртэл хувь)

4.2.5.3 тавьсан зорилтод хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 70.0 хувь (60.0-80.0 хүртэл хувь)

4.2.5.4 тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 50.0 хувь (40.0-60.0 хүртэл хувь)

4.2.5.5 тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 30.0 хувь (20.0-40.0 хүртэл хувь)

4.2.5.6 тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 хувь (0-20.0 хүртэл хувь)

4.2.5.7 тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийн хувийг "0" гэж үзнэ.

4.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүд:

4.3.1 Газрын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор улс, аймгийн төсвийг батлах, төсвийн тодотгол хийхээс өмнө үйл ажиллагааны чиглэл тус бүрээр төлөвлөгөө боловсруулан, шаардлагатай өртгийг нь тооцож, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгана.

4.3.2 Бодлогын зорилтын суурь болон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүн, үр нөлөөг тоон үзүүлэлтээр тогтооно. Тоон үзүүлэлт тогтоох боломжгүй бол чанарын шалгуур үзүүлэлтийг аль болох тодорхой тогтооно.

4.3.3 Тухайн үйл ажиллагаа болон бодлого хэрэгжиж эхлэх жилд төрийн байгууллагаас албан ёсоор гаргаж нийтэд мэдээлсэн тоон мэдээг суурь үзүүлэлт болгон авна.

4.3.4 Шалгуур үзүүлэлт нь дараах шаардлагыг хангасан байна:

4.3.4.1 Хамааралтай буюу ач холбогдолтой байх

4.3.4.2 Урт хугацаанд хэрэглэгдэх, тогтмол байх

4.3.4.3 Хэрэглэхэд хялбар, боломжтой байх

4.3.4.4 Аль болох богино хугацаанд өөрчлөлтийг илэрхийлэхээр байх.

4.4 Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх:

4.4.1 Газрын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнтэй холбогдуулан "Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө"-г баталж, дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.4.1.1 Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах

4.4.1.2 Газрын стратеги зорилтоос хариуцсан чиглэлийн хүрээнд албан хаагчид өөрийн ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх

4.4.1.3 Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн шаардлагатай тохиолдолд стратегийг хэрэгжүүлэх арга хэлбэр, зохион байгуулах үйл ажиллагааг өөрчлөх асуудлыг газрын Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тодотгох

-----oOo-----